

ЦӨМИЙН ДАЙНЫ ЭСРЭГ ОЛОН ТҮМНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ИХ ӨРНӨЛТ

Ш. Сандаг, түүхийн ухааны доктор

Цөмийн дайны эсрэг, пуужинт, зэвсгийн эсрэг олон түмний хөдөлгөөн өнөөдөр дэлхий даяар улам бүр эрч хүчээ авч урьд өмнө үзэгдээгүй өргөн далайцтай болж байна.

АНУ-ын засаг захиргаа дэлхийд америкийн империализмын ноёрхлыг тогтоохын тулд социалист орнуудын эсрэг «загалмайтны аян дайн» зарлан, хүн төрөлхтөнд хөнөөлт цөмийн дайн өдөөх аюултай замд шууд ороод байгаа үед дэлхийн сайн санаат олон түмний эсэргүүцлийн дуу хоолой улам сүрлэг цуурайтах болжээ.

ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга Ю. В. Андроповын 1983 оны 9-р сарын 28-ны мэдэгдэл нь ЗХУ даян дэлхийд улс түмний энх тайван, аюулгүй байдлын гол бат цайз болсоор байгааг харуулж, цөмийн ба бусад зэвсэглэлийг эрс хорогдуулах, пуужинт-цөмийн дайны аюулыг зайлуулахын төлөө тууштай зогсож байгааг дахин нотлов. Тэр мэдэгдлийг дэлхийн шударга хүн төрөлхтөн бүрэн дүүрэн сайшаан дэмжиж байна.

Ю. В. Андроповын Мэдэгдэлд АНУ-ын засаг захиргааны аюултай бодлогын хор уршгийг илчлэн няцааж, цөмийн дайны эсрэг олон түмний хөдөлгөөний нэгдэл нягтралыг улам бэхжүүлэхийн чухлыг заав.

Ю. В. Андропов цохон тэмдэглэхдээ, «Манай гаригийн бүх улс түмэн, хүн бүр заналхийлж буй аюулыг ухамсарлах ёстой. Аж төрлийнхөө төлөө тэмцэлд хүч чармайлтаа нэгтгэхийн тул үүнийг ухамсарлах ёстой.

Хүн төрөлхтөн эрүүл ухаанаа алдаагүй, алдах ч ёсгүй. Энэ нь Европ болон бусад тивд пуужингийн эсрэг, дайны эсрэг хөдөлгөөн өргөн далайцтай өрнөж, тэр хөдөлгөөнд нийгэм, улс төр, шашны өөр өөр үзэл бодол бүхий хүмүүс оролцож байгаа явдлаар тод томруун илрэн харагдаж байна»¹ гэжээ.

Ю. В. Андропов ЗХУ ба социалист бусад орны энх тайванч бодлого, санаачлага нь дэлхийн энхийг эрхэмлэгч хүчний амин чухал эрх ашигт нийцэж байгааг мөн цохон тэмдэглэв.

1983 оны эцсээр АНУ ба НАТО Баруун Европт дунд зайны тусгалт 572 пуужинг байрлуулахаар төлөвлөж одоо тэдгээрийг агуулах ба хөөргөх талбай бэлтгэх ажил ид өрнөж байгаа үед цэрэг—стратегийн талаар социалист орнуудаас давуутай болох залихай арга сүвэгчилж, цөмийн дайны ирмэгт манай дэлхийг түлхэж байгаа үед дайны хэнээтний энэ бүх өдөөн хатгалга, явууллагыг тас цохин зогсоох явдал хойшлуулшгүй зорилго болон тавигдаж байна.

¹Ю. В. Андроповын Мэдэгдэл.—«Үнэн», 1983 оны 9-р сарын 30.

Пуужинт—цөмийн дайны эсрэг өргөн олон түмний хөдөлгөөн нь уул хөдөлгөөнтэй эв санааны нэгдэлтэй бөгөөд засгийн газрынхаа энх тайванч бодлогыг тууштай дэмжигч ЗХУ ба социалист бусад орны ард түмнээс гадна ХБНГУ, Итали, Голланди, Дани, Швед, Бельги, Канад, АНУ, Япон зэрэг орнуудыг хамарч дэлхийн бөмбөрцөг даяар өрнөн өргөжсөөр байна.

Цөмийн дайны эсрэг, энх тайван, амьдралын төлөө олон нийтийн жагсаал, цуглаан, уулзалт БНМАУ даяар үргэлжлэн явагдаж АНУ ба НАТО-гийн аюултай балмад төлөвлөгөөг эрс буруушааж байна. Орчин үеийн амьдралын нэн чухал шаардлагыг тусгасан, хүн төрөлхтний амгалан тайван аж төрөх эрх дархыг хамгаалсан онцгой ач холбогдолтой баримт бичиг—ЗХУКН, Зөвлөлт төрийн тэргүүн нөхөр Ю. В. Андроповын 9-р сарын 28-ны Мэдэгдлийг энхийг эрхэмлэгч монголын олон нийт чин халуун сэтгэлээр угтан авч, манай гариг дээрх амьдралыг сөнөөж болох аймшигт дайны эсрэг дуу хоолойгоо нийлүүлж байна.

1983 оны 10-р сарын 8-нд нийслэлийн 70 мянган хөдөлмөрчид төв талбай дээр жагсаал хийж, «Нөхөр Ю. В. Андроповын Мэдэгдлийг сайшаан дэмжиж байна!», «Зөвлөлтийн энх тайвны программыг дэмжиж байна!», «Европт америкийн пуужинг байрлуулахыг хориглогтун!», «Дайн сөнөтүгэй!», «Рейганы засаг захиргааны харгис эрмэлзлэлийг тас цохигтун!», «Бидэнд энх тайван хэрэгтэй!» гэх мэт уриа, лоозун барьж, дэлхийн энхийг эрхэмлэгч хүчинтэй эв санааны нэгдэлтэй байгаагаа яруу тод илэрхийллээ.

Дайны эсрэг Улаанбаатарт болсон хөдөлмөрчдийн өргөн жагсаалд оролцогчид мэдэгдэл гаргаж ЗХУКН, Зөвлөлт төрийн тэргүүн Ю. В. Андроповын мэдэгдлийг чин сэтгэлээр талархан дэмжиж байгаагаа илэрхийлж, Европт америкийн шинэ пуужинг байрлуулахыг дэлхийн энхийг эрхэмлэгч хүчний хамт шийдвэртэй эсэргүүцэв. Хүн төрөлхтнийг цөмийн дайны ангалд түлхэн оруулахыг улайран хөөцөлдөж байгаа америкийн империализм ба түүний холбоотны адал балмад бодлогыг тас цохин зогсоохын чухлыг уриаллаа.²

Манай ах дүүгийн найрамдалт ЗХУ-ын олон нийт орон даяараа цөмийн дайны эсрэг өргөн цуглаан жагсаал хийж, даян дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахад зориг төгөлдөр байгаагаа сүр жавхлантайгаар илэрхийлж байна. Зөвлөлтийн нийслэл Москвад 1983 оны 10-р сарын 1-нд 800 мянган иргэдийн сүрт жагсаал болж, «Европт шинэ пуужинг байрлуулахын эсрэг тэмцэгтүн!», «Зэвсэглэлийг бүх нийтээр бүрэн хураахын төлөө!», «Зөвлөлтийн энх тайвны программыг хэрэгжүүлбэ!» гэх мэт уриа лоозун цуурайтаж байв.

Москвагийн өргөн жагсаал бол агуу их зөвлөлтийн ард түмэн ЗХУКН, Зөвлөлт засгийн газрынхаа ленинч гадаад бодлогыг тууштай сайшаан дэмжиж, АНУ ба НАТО-гийн сэдэж буй аюултай цөмийн дайныг өдөөлгөхгүй байхын тулд бүхнийг хийхэд бэлхэн байгаагийн яруу сайхан жишээ мөн.

Америкийн атомын бөмбөгт эрсдсэн Японы Хиросима, Нагасакид энэ 1983 оны 8-р сард цөмийн зэвсэг хориглох Олон улсын бага хурал 38 дахь удаагаа болж өнгөрсөн нь дэлхийн энхийг эрхэмлэгч хүчний эрч хүчийг илтгэн харууллаа.

Энэхүү Олон улсын бага хурал уламжлал ёсоор Токио—Хиросима— Нагасакид гурван шат болон хуралдаж, Японы дэвшилтэт олон нийт-

²«Үнэн» 1983. X. 9.

тэй дэлхийн энхийг эрхэмлэгчид очиж Хиросима, Нагасакийн эмгэнэлт явдлыг эгнэгт гаргахгүй байлгах, цөмийн зэвсгээр сүрдүүлж, цөмийн дайнд шургуу бэлтгэж байгаа америкийн империализмын хорт бодлогыг эрс тууштай эсэргүүцэх талаар хүч зоригоо нэгтгэх арга замыг хамтран хэлэлцжээ.

Уул бага хурлын анхан шат нь Токиод болж «Токиогийн тунхаглал» батлав. Тэрхүү баримт бичигт «Бид «хязгаарлагдмал» «хянаж болох» цөмийн дайны тухай, ялагчид байж болох дайны тухай номнолыг няцааж байна, учир нь ийм номлол хүнийг үй олноор устгах зэвсэг хэрэглэж болох бололцоог бий болгож байгаа нь ялт хэрэг мөн. Цөмийн хүчний тэнцүүр дээр айж эмээж байхын тэнцүүр дээр энх тайвныг сахин хамгаалах тухай тийм үзлийг бид буруушаан няцааж байна»³ гэж тэмдэглэжээ.

Токиогийн бага хурал дэлхийд хуримтлагдаад байгаа цөмийн хэрэгслийг нэмэгдүүлэхгүй байлгах, эхний алхамд цөмийн зэвсгийг шинжлэх ухаан ба практикийн үүднээс нарийсгах, ямар нэг туршилт хийх, үйлдвэрлэх, нөөцлөх, байрлуулах, хэрэглэх явдлыг бүрэн хориглох тухай гэрээ байгуулахыг санал болгов. Түүнчлэн Европт цөмийн зэвсэглэл хорогдуулах тухай хэлэлцээрийг түргэн дуусгахыг шаардан, Японы энхийг эрхэмлэгчидтэй эв санааны нэгдлээ илэрхийлэн, тус орны усан боомт хотуудад цөмийн зэвсэг тээсэн цэргийн хөлөг онгоцууд орохыг эсэргүүцэн, японы цэргийн зардал төсөв нь нэмэгдэж байгааг буруушаан, түүнийг Алс Дорнодод америкийн цөмийн стратегийн хүрээнд татан оруулахад чиглэсэн алсын хорон санаат бодлогыг илчлэн няцаав.

Энх тайвны төлөө Францын олон нийтийн хөдөлгөөний Үндэсний Зөвлөл тус орны хүн иргэдийг зэвсэглэл хураах, дайны аюулыг сэрэмжлэх тэмцэлд зохион байгуулж өргөнөөр оролцуулж байна. Тус Зөвлөлийн уриалганд цөмийн нөөцийг нэмэгдүүлэхгүй байх, Европт шинэ пуужинг байрлуулахгүй, Европ дахь цөмийн зэвсэглэлийг хорогдуулах талаар зөвлөлт—америкийн Женевийн хэлэлцээнд харилцан тохирсон шийдвэр гаргах, хүнийг үй олноор алан хядах хэрэгслийг эхлээд хорогдуулан, улмаар устгах талаар Франц улс санаачлага гаргах зэрэг шаардлага тавьжээ.

Италийн газар газраас хүрэлцэн ирсэн энхийг эрхэмлэгч хүчнүүд Сицилийн Комизо хотын ойролцоо хүрэлцэн ирж тэнд америкийн далавчит пуужинг байрлуулахаар бэлтгэж буй баазтай холбосон зам харгуйг боож, америкийн пуужинг Италид авчрахыг эрс эсэргүүцсэн олны жагсаал үргэлжилж байна. Комизо хот дахь энх тайвны талынхныг харгис цагдаа нар элдвээр хавчин цээрлүүлэн шийтгэж байгааг Италийн Милан ба бусад олон хотын иргэд эрс эсэргүүцэн америкийн пуужинг тус оронд хэрхэвч байрлуулахгүй гэсэн лоозун уриа цуурайтуулж байв.

Баруун Берлинд 1983 оны 9-р сарын эцсээр социал—демократ намын их хурал «Энх тайвныг хамгаалж намжмал байдлыг хангаж, зэвсэглэл хураая!» гэсэн лоозунгийн дор болж өнгөрлөө. Тус их хурал Баруун Европт америкийн пуужинг байрлуулахыг эсэргүүцэн Рейганы «завсрын хувилбар» гэгчийг шүүмжилж энэ бол пуужинг байрлуулж эхлэхийн хамт, Женевийн хэлэлцээг үргэлжлүүлэхэд чиглэсэн залихай арга мөн болохыг уудлан няцаав. Мөн олон хүн тус хурлын индэр дээрээс цөмийн «хязгаарлагдмал» дайны тухай америкийн номлол гэгчийг илчлэв.

Голландын олон нийт тус оронд америкийн далавчит пуужинг байрлуулахыг эсэргүүцсэн хөдөлгөөнийг өрнүүлж байна. Вунсдрехт мужийн агаарын цэргийн баазад дээрх пуужинг агуулах бэлтгэл ажил явагдаж байгааг даруй зогсоохыг шаардацгаах боллоо.

Испанийн нийслэл Мадридаас 30 км-т орших Алькала—де—Энарес хотын захиргаа тус хотоо цөмийн зэвсэггүй бүс болгон зарлаж, түүгээр аливаа цөмийн хэрэгсэл тээх явдлыг хориглох тухай шийдвэр гаргажээ. Энэ нь Мадрид мужид газар нутгаа цөмийн зэвсэггүй бүс болгон зарласан зургаадахь хот нь болжээ.

Шинэ Зеландийн «Нью Зиленд трибюн» сонин тус орны энх тайвны талынхны хүсэл эрмэлзлэл, үзэл саналыг тусган, АНУ-аас хүн төрөлхтөнд хөнөөлт цөмийн дайн өдөөх төлөвлөгөөг илчлэн, ЗХУ-ын зохистой гадаад бодлогыг сайшаан дэмжсэн ухуулах хуудас нийтэлжээ. «Хоёр их гүрэн, хоёр өөр бодлого» гэж гарчиглаж Европт дунд зайны цөмийн зэвсэг байрлуулахаас татгалзах, Европт цөмийн зэвсэггүй бүс байгуулах, «хязгаарлагдмал» буюу өөр ямар нэг хэлбэрийн цөмийн дайн дэгдээхийг сэрэмжлэх, цөмийн зэвсгийг эхлэн хэрэглэхээс татгалзах, нейтроны бөмбөг үйлдвэрлэхийг хориглох, цөмийн зэвсгийг нэмэгдүүлэхгүй байх, цөмийн зэвсгийн бүх туршилтыг зогсоох, цөмийн зэвсгийг устгах, цэргийн эвсэл холбооноос татгалзах, НАТО ба Варшавын гэрээний байгууллагыг нэгэн зэрэг татан буулгах зэрэг асуудлаар ЗХУ, АНУ хоёр эсрэг тэсрэг байр суурь баримталж байгааг тодорхойлж ЗХУ-аас гаргаж буй даян дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахад чиглэсэн их хүч чармайлтыг өндрөөр үнэлсэн юм.

Атомын бөмбөгдөлтөд анхлан амь үрэгдэгсдийн дурсгалыг тэмдэглэхээр Английн 15 хотоос энхийг эрхэмлэгч хөдөлгөөний талынхан 600 хүн агаарын онгоцны Гринэм—Коммон баазад очиж дэргэд нь гурван хоног майхан барьж байгаад эсэргүүцлээ илэрхийллээ.

Цөмийн дайны аюулыг зайлуулах хөдөлгөөн АНУ-д ч өргөжсөөр байна. Америкийн дэвшилтэт олон нийт бүх орон даяар Рейганы засаг захиргааны мухар сохор, хэнээт бодлогыг илчлэн, ЗХУ ба социалист бусад орны сайн санаат хүч чармайлтыг сайшаан дэмжиж, цөмийн дайны эсрэг, пуужинт зэвсгийн эсрэг сүрт жагсаал хийсээр байна. Үүнд нэг жишээг дурьдвал Сан—Франциско хотын ойролцоох Окленд усан боомтод 9-р сард болсон явдал сонирхолтой байна. Баруун Германы усан онгоцны компани «Гепаг—Ллойд» тус оронд байрлуулах америкийн «Першинг—2» пуужингийн эд ангиудыг тээлгэн авчруулахаар нэгэн ачааны хөлөг онгоцоо Оклендэд явуулсанд тэр онгоцны нь командын ихэнх нь ийм аюултай ачаа авахаас татгалзаж, Америк дахь энхийг эрхэмлэгчидтэй эв санааны нэгдлээ харилцан илэрхийлцгээсэн байна.

Ази тивийн энхийг эрхэмлэгч хүчнийг цаашид өрнүүлэн, цөмийн дайны аюул заналыг арилгах ариун тэмцэлд нэгдэл нягтралыг нь бэхжүүлэх хэрэгт Улаанбаатарт 1983 оны 4-р сард болсон «Ази, Номхон далайн энх тайван, аюулгүй байдлын төлөө бүсийн бага хурал» чухал байр суурь эзлэнэ.

Тус бага хурлаас баталсан Төгсгөлийн тунхаглалд манай гаригийг халуун цөмийн сүйрлийн ноцтой аюул хэзээ хэзээнээс илүү нөмрөөд байгааг дэлхийн олон нийтэд илэн далангүй мэдэгдэн тэрхүү аюул заналын эсрэг олон түмний хөдөлгөөн тэмцлийг улам бүр хүчтэй болгохын чухлыг онцлон заав.

Улаанбаатарын бага хуралд оролцогчид Ази, Номхон далайн улсуудын хоорондын харилцаанд үл довтолох, хүч үл хэрэглэх тухай

Конвенц байгуулах талаар БНМАУ-ын дэвшүүлсэн саналыг дэмжиж түүнийг «энх амгалан байдал, харилцан ойлголцох итгэлцэх уур амьсгалд аж төрөхийг эрмэлзэн хүсэж байгаа улс түмний язгуур эрх ашгийг хэрэгжүүлэхэд цаг үеэ олсон чухал ач холбогдолтой»⁴ гэж дүгнэв.

Дэлхий дахины энхийг эрхэмлэгч хүчнүүдийн эв санааны нэгдлийг бэхжүүлж, дэлхийн шинэ дайны эсрэг тэмцлийг эрчимжүүлэхэд Прагад болсон «Энх тайван, амьдралын төлөө, цөмийн дайны эсрэг» Бүх дэлхийн Ассамблей онцгой үүрэг гүйцэтгэлээ. 1983 оны зургадугаар сарын 21—26-нд хуралдсан энэхүү ассамблейд дэлхийн 132 орны өөр өөр арьстан, үндэстэн, өөр өөр үзэл бодол, шашин шүтлэгтэй 3 мянга орчим төлөөлөгчид оролцож, манай дэлхийд америкийн империализм ба НАТО-гийн эзэрхэг түрэмгий бодлогоос болж нөмөрсөн цөмийн дайны аюулыг зайлуулж энх тунх амьдралыг сахин хамгаалах тухай тулгамдсан асуудлыг хамтран хэлэлцэж, хамтын зориг эрмэлзлэл тусгасан дүгнэлт, шийдвэр гаргасан билээ.

Прагийн ассамблейд оролцогчид, дайны эсрэг хөдөлгөөний нэрт зүтгэлтнүүд зэвсэглэл, ялангуяа цөмийн зэвсэглэлээр хөөцөлдөж буй АНУ ба НАТО-гийн эзэрхэг түрэмгий бодлогыг бүх талаар шүүмжлэн няцааж, Өрнөд Европт «Першинг—2», далавчит пуужин байрлуулах тухай Рейганы засаг захиргааны шийдвэрийг эсэргүүцэв. Цөмийн зэвсгээр хөөцөлдөж байгаад АНУ, ЗСБНХУ хоёр «адилхан хариуцлага» хүлээх тухай номлол гэгч нь ямар ч үндэсгүй, америкийн империализмын жанжлах бодлогыг хаацайлан хамгаалсан болохыг олонхи төлөөлөгчид илрүүлэн шүүмжилж Умард Европ, Балтын тэнгисийн бүс нутаг, Балканы хойг, Газрын дундад тэнгисийн бүс нутагт цөмийн зэвсэггүй бүс байгуулах төслийг Прагийн чуулга уулзалт сайшаав. Мөн өөртөө цөмийн зэвсэггүй бүх улсыг хамруулан «Европт аюулгүй байдлын өргөн бүсийг» байгуулах тухай саналыг дэмжив. Ази, Африк, тодорхой яривал Энэтхэгийн далай, Персийн булан, Улаан далайн сав газарт орших бөгөөд эвсэлд нэгдээгүй 19 орны эсрэг чиглэсэн АНУ-ын «цэргийн төв командлал» гэгчийг байгуулсан явдлыг эрс буруушаав.

Прагийн чуулга уулзалтад оролцогчид ЗХУ ба социалист бусад орон, Варшавын Гэрээний орнуудын энх тайванч гадаад бодлого, сүүлийн үед даян дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх талаар дэвшүүлсэн санал, санаачлагуудыг бүрэн дүүрэн дэмжиж байгаагаа илэрхийллээ.

Прагийн ассамблейн Төгсгөлийн баримт бичигт дэлхийн энхийг эрхэмлэгч хүчин энх тайван, аюулгүй байдлыг сахин бэхжүүлж, цөмийн дайны аюулыг зайлуулах хэрэгт үүрэг нь улам өсөн нэмэгдэж байгааг зүй ёсоор үнэлсэн билээ. «Энх тайвны төлөө нийтийн хөдөлгөөн нь чухал хүч, энх тайвныг сахин хамгаалах хэрэгт засгийн газруудын явуулж байгаа практик бодлогод нөлөөлөх чадвартай олон улсын байдлыг тодорхойлогч нэг хүчин зүйл болж байна»⁵ гэж уул баримт бичигт дурьдсан ажээ.

Прагийн ассамблейн дараагаар 1983 оны 9-р сарын 26—28-нд дайныг эсэргүүцэх олон нийтийн байгууллагуудын Олон улсын бага хурал Женевт болж өнгөрөв. Тус бага хуралд олон улсын 50, үндэсний 41 байгууллагын 155 төлөөлөгчид хүрэлцэн ирж, цөмийн ба бусад зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг зогсоох, цөмийн дайны аюулыг сэрэмжлэн зайлуулахтай холбогдсон тулгамдсан асуудлуудыг авч хэлэлцэв.

⁴ Ази, Номхон далайн энх тайван, аюулгүй байдлын төлөө бүсийн бага хурлын төгсгөлийн тунхаглал.—«Үнэн», 1983 оны 4-р сарын 23

⁵ «Үнэн» 1983. VI. 28.

БНМАУ-ын саналаар НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1978 онд жил бүрийн аравдугаар сард «Зэвсэг хураах зорилгод тус дөхөм үзүүлэх олон улсын долоо хоног» зохион явуулж байх тухай чухал шийдвэр гаргасан билээ. Женевийн зөвлөлдөх бага хурал дээр энэ 1983 оны 10-р сард зэвсэг хураах талаар явуулах үйл ажиллагааны долоо хоногийг дэлхий даяар өргөн явуулж, пуужинт зэвсгийн эсрэг олон нийтийн сүрт жагсаал, суртал нэвтрүүлэг эрчимтэй явуулахыг чухалчлан заав.

Дээрх Зөвлөлдөх бага хурлаас гаргасан Ерөнхий мэдэгдэлд өгүүлэхдээ «Хүн төрөлхтөнд цөмийн дайнд сөнөх аюул тулгаран ирлээ. Аюултай цөмийн зэвсэг бай байндаа чиглэн байрлагдаж хэзээ ч хөөрч одоход бэлхэн болоод байна. Эдгээр нүгэлт онисуудыг санамсаргүйгээс алдаж эндсэнээс буюу зориуд санаатайгаар хэрэглэвэл, газар дээрх амьдралыг устгаж, хүн төрөлхтөн үеийн үед бүтээсэн бүхнийг үгүй хийх л ганцхан үр дүнд хүрнэ. Энэ хэнээт балмад явдлыг өөрчилж, цөмийн сүйрлийг сэрэмжлэн зогсоож, цөмийн зэвсгийг устгах хэрэгтэй. Улс түмэн ийм зэвсэггүйгээр ийм дайнгүйгээр энх тунх амьдралаа зохиож чадна. Энэ зорилгыг ахар богино хугацаанд биелүүлэхийн тулд дэлхий даяар зэвсэглэл хорогдуулах кампанид хамтран зүтгэж, эв санааны нэгдлээ бэхжүүлэх хэрэгтэй»⁶ гэж тэмдэглэжээ.

Цөмийн дайны эсрэг даян дэлхийд улам эрчимтэй өрнөсөөр буй олон түмний хөдөлгөөн нь ЗХУ ба социалист бусад орны энх тайванч хүчин чармайлттай нийлэн хүн төрөлхтнийг энэхүү тулгараад байгаа аюул заналаас аварч чадна гэдэгт итгэл төгс байна.

Энэ тухай МАХН-ын Төв Хорооны 1983 оны 7-р сарын VI бүгд хурал дээр МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбал хэлсэн үгэндээ цохон тэмдэглэхдээ, «АНУ-ын харгис бүлэг, тэдний НАТО-гийн хань хамсаатнууд «Зөвлөлтийн цэргийн аюул» гэгч худал цуурхлаа улам дэвэргэж, дэлхийн дайнд нийтээрээ бэлтгэн, дайны хэнээрхэл дэгдээж, цөмийн дайн хийж болно, тэр ч байтугай түүнд ялж болно гэх мэтийн мунхаг үг яриагаар хүмүүсийн оюун бодол, санаа сэтгэлийг хордуулж байна.

Гэвч дэлхийн эрүүл саруул сэтгэдэг олон нийт энэ аюултай хандлагыг буцаан эргүүлж болох бөгөөд тэгэх ч ёстой, хүн төрөлхтнийг нөмрөөд байгаа халуун цөмийн сүйрлийн аюулыг зайлуулж чадах хүч дэлхий дээр байна гэж итгэж байна. Энх тайвны төлөө тэмцэл өдрөөс өдөрт өрнөж, дайны эсрэг хүч улам бүр зузаарч байна»⁷ гэжээ.

ПОДЪЕМ МАССОВОГО ДВИЖЕНИЯ ПРОТИВ ЯДЕРНОЙ ВОЙНЫ

(Р е з ю м е)

Нашу планету охватывает массовое антиядерное, антиракетное движение, которое приобретает все более широкий размах, ибо люди доброй воли везде и всюду сознают растущую угрозу ядерной войны, могущей в считанные минуты испепелить жизнь и цивилизацию на нашей земле.

⁶Женевийн Зөвлөлдөх бага хурлын Ерөнхий мэдэгдэл. «За рубежом», 1983. №41. с. 13.

⁷Ю. Цэдэнбал. МАХН-ын Төв Хорооны VI бүгд хурал дээр хэлсэн үг. —«Үнэн» 1983 оны 7-р сарын 20.

Крайне обострившаяся современная международная обстановка, вызванная безрассудной, авантюристической политикой администрации Рейгана. Американские агрессивные круги вкуче с НАТО и своими союзниками на Востоке задались целью добиться военно-стратегического превосходства над СССР и другими социалистическими странами, установить глобальную гегемонию. Не отказываясь даже от развязывания ракетно-ядерной войны, они тешат себя надеждой на иллюзорную победу в подобной войне.

В такой обстановке вполне закономерно ширится по всему миру массовое антивоенное движение. Многолюдные митинги и демонстрации, в которых участвуют люди доброй воли независимо от их расовой, религиозной и политической принадлежности, происходят всюду на нашей планете.

Перед лицом постоянно растущей угрозы все, кому дорог мир, включается в широкое антиядерное движение, призванное отстаивать священное право людей на мирную жизнь.

В этой связи поистине широкий резонанс во всем мире имело Заявление Генерального секретаря ЦК КПСС, председателя Президиума Верховного Совета СССР тов. Ю. В. Андропова от 28-го сентября 1983 г., в котором вновь указан путь конструктивного решения неотложных задач по сокращению ядерных вооружений, за укрепление всеобщего мира.

Народы социалистических стран, всецело поддерживающие миролюбивую политику своих правительств, в эти дни вновь демонстрируют свою решимость отвести реальную угрозу ядерной войны и отстаивать мир и международную безопасность. В этой связи, автор ссылается на грандиозную 800 тысячную антиядерную демонстрацию жителей Москвы, а также массовые митинги и манифестации, развертывающиеся по всей Монголии.

Антиядерные, антиракетные демонстрации и митинги, встречи и диалоги, имеющие место в Голландии Дании, Италии, Швеции, Англии, ФРГ, США, Японии и др. странах, говорят о широком размахе анти-ядерного движения всех миролюбивых сил в мире.

Движение мировых сил, выступающих за избавление человечества от возрастающей угрозы ядерного уничтожения, приобретает невиданный доселе размах и динамизм, с чем не могут не считаться авантюристы из Вашингтона.